

“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2025 оны 04- р сарын 28 нд

Хурал эхэлсэн цаг: 11.10

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

- 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
- 2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан
- 3. 2025 оны зорилт, төлөвлөгөө
- 4. Ногдол ашгийн тухай

Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Нарантуяа хурлын дэгийг танилцуулав.
Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх хүн байна уу?
Хурлын дэгтэй холбоотой санал өгөх хүн **Байхгүй** хурлын дэгийг батлав.

ХЗБ комиссын дарга: Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг сонгох саналтай байна, Та бүхэн саналаа хэлнэ үү?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг томилохыг 100 хувийн саналаар зөвшөөрлөө. Тогтоол № 01-ийг уншиж танилцуулав.

Хурлын ирц: Хувьцаа эзэмшигчдийн хуралд ҮЦТХТ ХХК- иас 2025 оны 04 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт **12,545,061** ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсон нь саналын эрхтэй нийт **15,869,233** ширхэг хувьцаанаас **79,05 %** болсон тул хурал хүчин төгөлдөр болсон. Тооллогын комиссын тогтоолыг № 02 танилцуулав

Нийт хувьцааны тоо	15 869 233
Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо
Ц.Чингүүнболд	1 824 000
Б.Цогтгэрэл	3 548 345
Б.Батцэнгэл	28 076
Ц.Оргилболд	912 000
Б.Осолгүйгэрэл	30 000
С.Баярцэцэг	6 000
Б.Нарантуяа	4 281 920
“БиДиСек ҮЦК” ХК	1 260 990
“Тасган инвест” ХХК	653 730
Нийт ирсэн нь	12 545 061

Нийт хувьцаанд эзлэх хувь	79,05 %
---------------------------	---------

Б.Нарантуяа: За хурлын дэгийн дагуу хурлын даргыг сонгох ёстой, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Цогтгэрэлийг сонгох саналтай байна?

Эсрэг саналтай хүн гараагүй тул 100 хувийн саналаар Б.Цогтгэрэлийг ХЭХ-ын даргаар сонгов. Тогтоолыг № 03 уншиж танилцуулав.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлын дарааллаар Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа: "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метрийн урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-аас түншлэлийн хүрээнд нийт шугам угсралтыг суурилуулж дууссан ба туршилт тохируулга алдагдал олох ажлууд үлдээд байна. Энэхүү төслийн ажлыг 2017 оны үнэлгээгээр 6 дахь жилдээ сунган гүйцэтгэж байгаа нь алдагдал өсөх бодитой шалтгаан болсон. Гэрээний хугацаа сунгах үндсэн шалтгаанууд нь авто зам хуулж хийх зөвшөөрөл богино хугацаатай гардаг, газар чөлөөлөлт хугацаандаа хийгддэггүй зэрэг үндсэн шалтгаануудаас хамааралтай байдаг.

Зөвхөн энэ төслийн хувьд компани өнөөдрийн байдлаар 1.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд байна. Алдагдал үүссэн нөхцөл байдалд дан ганц компанийн үйл ажиллагаанаас бус дэлхий дахины цар тахлын нөхцөл байдал, бензин шатахуун, барилгын материалын үнийн өсөлт, ханшийн зөрүүний алдагдал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өссөн, ндш-ийн хувь хэмжээ өссөн, төр засгийн шийдвэр хугацаандаа гардаггүй зэрэг хөндлөнгийн шалтгаанууд шууд нөлөөлдөг. Энэ жил улсын комисст хүлээлгэж өгнө.

Өнгөрсөн 2024 онд "Таванбогд пропертис" ХХК-ийн захиалгаар Хан-Уул дүүргийн 11-р хороонд 440 метрийн урттай 770 сая төгрөгийн төсөв бүхий ажлыг хийж гүйцэтгэн, улсын комисст байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Гүйцэтгэх захирлын 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн хувьд "хангалттай" гэж ТУЗ дүгнэсэн. 2024 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны зээл төлөлт, зээлийн хүүг бууруулах болон авлага өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна. Иймд санхүүгийн үйл ажиллагааг "хангалттай" гэж дүгнэсэн.

Гүйцэтгэх захирлын тайлантай холбоотой асуух зүйл байна уу?

Б.Нарантуяа: Өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр, төлбөр ихтэй, алдагдлаа нөхөх боломж гарахгүй байгаа тул аливаа тендерт оролцох шалгуурыг хангахгүй байна. Ер нь төрийн худалдан авалтад оролцоход үнэлгээ маш доогуур, санхүүжилт их гацдаг зэргээс алдагдал үүсэх нөхцлүүд үүсч байна.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Хуралд хөндлөнгийн хяналтаар Ниямазон аудит ХХК-ийн Э.Нарангэрэл аудитор ХЭХ-д оролцож байна.

Хувьцаа эзэмшигч Батцэнгэл: Би анх 2005 онд энэ компанийн хувьцааг ирээдүйд өсөх үнэ цэнэтэй гэж худалдан авч байсан. Гэтэл өнөөдрийг хүртэл үр ашгийг нь хүртэж чадахгүй байна. Цаашид яах вэ?

Б.Нарантуяа: Манай компани 1997 онд хувьцаат компани болж зохион байгуулалтаа өөрчилснөөс хойш ногдол ашиг тараасан удаа байхгүйн байна лээ. Өнөөдөр ч ялгаагүй төрийн худалдан авалт хийж ажил гүйцэтгэдэг, төр ажлаа хийлгэчихээд төлбөрөө өгөхгүй он дамжуулдаг, тэгж байтал татвар нь баахан шалгалт гээд торгууль алданги бичээд данс хаадаг ийм л жишгээр олон жил явж ирсэн байна. Өмнөх жилүүд буюу 2016 оноос хойшхи өр төлбөрийн дарамт одоо хүртэл үргэлжлэн явж байгаа бөгөөд санхүүгийн хувьд дөнгөн данган л байна. Ер нь манай хийдэг ажлын төсвийн үнэлгээ хамгийн бага байгаа тул /бусад ижил төстэй ажил хийдэг авто зам гэх мэттэй харьцуулахад/ энэ оны 3 дугаар сард Хот байгуулалтын сайдтай уулзаж танилцуулсан.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: За өөр асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал 2025 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулах уу?

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа 2025 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулав.

Хурлын дарга: Та бүхнээс энэ асуудалтай холбоотой асуух зүйл байна уу?

2025 оны төсөв төлөвлөгөөг батлах уу?

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ХЭХ-аас 2025 оны санхүүгийн төсвийг баталлаа.

Хурлын дарга Б.Цогтгэрэл: -Дараагийн хэлэлцэх асуудал ногдол ашгийн тухай. 2024 оны компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор ТУЗ-ийн 2025 оны 02 дүгээр сарыг 1802-ны өдрийн ТУЗ25/01 тоот тогтоолоор Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

-Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэв.

-Компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэв.

-Компанийн 2025 оны зорилт, төлөвлөгөөг батлах

-Компани 2024 онд Ногдол ашиг тараахгүй байх

Хурал 12.10 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДАРГА

Б.ЦОГТГЭРЭЛ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

О.ОЮУНЖАРГАЛ